

Завханбаялаг ХК-ний

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл

2016. 04.24

Улиастай сум

Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2016 оны 04-р сарын 24-ны өдрийн 14 цагт Завхан аймгийн Улиастай сум, Завханбаялаг ХК-ны байранд болов.

Хуралд : Тус компанийн хувьцаа эзэмшигч Л.Юра, Я.Өлзийбүрэн, Бат-Эрдэнэ нар хүрэлцэн ирж, Хувьцаа эзэмшигч Зочин-Эрдэнэ итгэмжлэлээр оролцож Хуралд урилгаар ТУЗ-ийн гишүүн Д. Санжмятав, Ц.Чанцаа, Г.Түвшинбат, Завханбаялаг ХК-ний удирдах ажилтан Д.Даваажаргал, Л.Лхамжав нар оролцов.

Хурлыг ТУЗ-н дарга нээж хурлыг удирдан явуулж, дотоод журам, дэг, Хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр батлуулав.Үүнд :

1. Компаний 2015 онд хийсэн ажлын тайлан, цаашдын зорилтыг батлах, санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын дүгнэлтийг батлах
2. Компаний дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
3. Компаний удирдлагын зардлыг батлах
4. Ноогдол ашиг хувиарлах эсэх талаар гарсан ТУЗ-н шийдвэрийг батлах
5. Аудитын байгууллагыг сонгох гэрээг батлах
6. ТУЗ-ын гишүүдийг сонгох

1. Завханбаялаг ХК-ний 2015 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Г.Түвшинбат уншиж танилцуулав
2. 2015 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн Аудитын дүгнэлтийн илтгэх хуудасыг Л.Лхамжав уншиж танилцуулав. / Тайлант хавсаргав /
3. Асуудлуудыг Хамтад нь шийдэхийн тулд Хурлаас гарах тогтоолын төслийг хурлын дарга уншиж танилцуулав.

Хэлэлцсэн асуудлаар гишүүд болон хуралд оролцогсод санал шүүмжлэл гаргав.

Я.Өлзийбүрэн

Хурлаар оруулж хэлэлцүүлж байгаа мэдээлэл, тогтоолын төслүүдтэй танилцлаа.

Компанийг хаалттай компани болгон өөрчлөн байгуулах нь зүйтэй байна. Хувьцаат компанийг жинхэнэ утгаар нь ажилшуулах цаг хугацаа нь болоогүй байна. Монголын хөрөнгийн зах зээл хөгжөөгүй байгаа учир саналыг дэмжиж байна.

Харин тусгай даалгаварыг ТУЗ-өөс боловсруулж удирдлагад үүрэг болгох нь зүйтэй. Хийх анхаарах зүйл их байгаа. Аудитын байгууллагыг хуулийн хүрээнд зайлшгүй ажиллуулж компанийй дүрмэнд тусгах шаардлагатай гэж ойлголоо үүнийг дэмжиж байна.

Ц.Чанцаа

Мэдээлэлийг сонслоо Зарим асуудлаар саналаа хэлэхийг хүсэж байна

Ашиг хувиарлалтын талаар анхаармаар байна. Жилийн ажлын үр дүгнээр хувь эзэмшигч нарт ашиг хүртэх боломжийг дараа шилээс олгох хэрэгтэй

Л.Юра

Хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргээ. Энэхүү хуралд компанийн удирдлага оролцож байгаа тул хурлын шийдвэр ба хуралд яригдсан асуудлыг хэрэгжүүлэх талаар ярилцаж ажиллах хэрэгтэй. Бид анхаарах асуудлын талаар тусгайлан хэлэх болно. Гүйцэтгэх удирдлага богино хугацаанд ажилласан хэдий ч ажлын эхлэл амжилт үр дүн байна. Мөн анхаарах асуудлууд ч байна. Дэлгүүр ба үйлдвэрийн өнгө үзэмжийг сайжруулах талаар анхаармаар байна. Цаг үеийг дагаж өөрчлөгдөж хөгжих Улиастайн өнгө нэмэж байна бид хоцрох ёсгүй манлайлж ажиллах хэрэгтэй өмнө би тийм зорилго тавиж ажилладаг байсан. Илүүдэл хөрөнгийг эргэлтэнд оруулах ашиглалтыг сайжруулах талаар их зүйл хийх хэрэгтэй. 2015 онд хийхээр төлөвлөсөн асуудлын биелэлт хангалтгүй байна. Үүнд анхаарч 2016 онд шинэ ажил хийнэ гэж найдаж байна.

Хаалттай компани болох асуудлыг энэ хурлаар шийдэх нь зөв. Бид бирж дээр хувьцаа гаргах хүртэл их хугацаа байх шиг байна. Иймд энэ хувилбарыг сонгох нь зөв гэж үзэж байна. Хурлын тогтоолуудыг батлах саналтай байна. Мөн компанийн дүрмэнд өөрчлөлт оруулж аудитын байгууллагыг ажиллуулах нь зөв юм.

Өөр санал хэлэх хүн байхгүй тул саналыг таслаж санал хураалт явуулах ажлыг тооллогын комисс байгуулав. Санал хураалтанд санал өгөх эрхтэй 4 хувьцаа эзэмшигчдэд саналын хуудсыг тооллогын комисс тараан өгч нууцаар санал хураалт явуулав. Санал хураалтын дүнг нэгтгэж танилцуулав.

Санал хураалтаар

1. Комканий 2015 оны хийсэн ажлын тайлан түүнд хийсэн дүгнэлтийг батлах тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар дэмжсэн.
2. Компанийн дүрмэнд өөрчлөлт оруулж компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг 100 хувийн саналаар дэмжлээ.
3. Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг мөн Компаний удирдлагын зардлыг 35.0 сая төгрөгөөр батлахаар хуралд оролцогчид 100 хувийн саналаар дэмжсэн.
4. ТУЗ-ийн гишүүнд 10 хүний нэр бичиж санал хураахад
 1. Я.Өлзийбүрэн

2. Л.Юра
3. П.Баянмөнх
4. Ю.Бат-Эрдэнэ
5. М.Алтанцэцэг
6. Д.Санжмятав
7. Ц.Чанцаа
8. Г.Түвшинбат
9. Т.Мөнхбаатар

Нарыг 100 хувийн саналаар дэмжсэн байгааг танилцуулж тооллогын комиссын тогтоолыг
Л.Хамжав танилцуулав./ санал хураалтыг явуулж тооллогы хуудсыг хавсаргав./

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр :

1. Компаний 2015 оны хийсэн ажлын тайлан түүнд хийсэн дүгнэлтийг хувьцаа
эзэмшигчдийн 100 хувийн саналаар 1-р тогтоол батлагдав.
2. Компанийн дүрмэнд өөрчлөлт оруулж компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг 100
хувийн саналаар 2-р тогтоол батлагдав.
3. Санхүүгийн тайлан,аудитийн дүгнэлтийг мөн Компаний удирдлагын зарлагыг 35.0
сая төгрөгөөр батлахаар хуралд оролцогчид 100 хувийн саналаар батлав
4. Зохион байгуулалтын асуудал :ТУЗ-ын 9 –өөс дээш гишүүнтэй байх дүрэмтэй
үүний дагуу ёмнө нэр дэвшүүлсэн хүн бүр дээр ярилцаж нэрийн жагсаалтанд
дараах хүмүүсийн нэрийг дэвшүүлэв.
 1. Я.Өлзийбүрэн
 2. Л.Юра
 3. П.Баянмөнх
 4. Ю.Бат-Эрдэнэ
 5. М.Алтанцэцэг
 6. Д.Санжмятав
 7. Ц.Чанцаа
 8. Г.Түвшинбат
 9. Т.Мөнхбаатар

Санал хураалтын хуудсыг хувьцаа эзэмшигч нарт тарааж хэлэлцэж байгаа асуудлаар
саналыг авч нэгтгэсэн дүнг хурлын нарийн бичгийн дарга гаргав.Санал хураалтыг явуулж
тооллогын хуудсыг хавсаргав.

Санал хураалтанд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар дараах асуудлыг
шийдвэрлэв.Компаний ТУЗ-ийн гишүүнийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж дор
дурьдсан хүмүүсийг ажиллуулахаар батлав.

1. Я.Өлзийбүрэн
2. Л.Юра
3. П.Баянмөнх
4. Ю.Бат-Эрдэнэ
5. М.Алтанцэцэг
6. Д.Санжмятав
7. Ц.Чанцаа
8. Г.Түвшинбат
9. Т.Мөнхбаатар

Хурал хэлэлцэх асуудлаа дууссан тул хурлыг 16 цагт хурлыг хаав .

Хурлын тэмдэглэл хөтөлсөн

Хурлын нарийн бичгийн дарга Лхамжав / Л.Лхамжав /

Хурлын тэмдэглэлтэй танилцсан

Хурлын дарга Ю.Бат-Эрдэнэ / Ю.Бат-Эрдэнэ /

ЗАВХАНБАЯЛАГ ХК-НИЙ БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр сар 24

Дугаар.....

Улиастай сум

Ажлын тайлан , санхүүгийн балансын дүнгийн тухай

Компаний ТУЗ-өөс хэлэлцүүлсэн 2015 оны ажлын тайлан, Санхүүгийн тайлан зэрэг мэдээлэлүүдийг сонсоод компанийн бүх гишүүдийн хурлаас тогтоох нь:

1. Завханбаялаг ХК-наас 2015 онд хийсэн ажлын тайланг хангалттай гэж үзсүгэй.
2. 2015 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн Аудитын дүгнэлтийг зөвшөөрсүгэй
3. ТУЗ-ийн 2016 оны 02 тоот тогтоолоор шийдвэрлэсэн компанийн ашгийг хувь нийлүүлэгчдэд хувиарлахгүйгээр байх шийдвэрийг дэмжсүгэй
4. 2016 онд компанийн борлуулалт маркетингийн болон санхүү, техник технологийн салбарт ахиц өөрчлөлт гаргаж, , удирдлагын бүтэц зохион байгуулалтыг сайжруулж , Бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хэмжээг нэмэгдүүлж , Улаанбаатар болон бусад аймгуудын зах зээлд гарах талаар оновчтой арга хэмжээ авч эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, Гадаад худалдааг өргөжүүлэх, Чацааргана жимсний суулгац тариалах, хөрөнгийн эргэцийг түргэтгэх зэрэг асуудалд онцгой анхаарч ажиллахыг Завханбаялаг ХК-ны ТУЗөвлөл ба гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

Хурлын дарга

Ю.Бат-Эрдэнэ

Нарийн бичгийн дарга

Л.Лхамжав

ЗАВХАНБАЯЛАГ ХК-НИЙ БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо 2016 оны 4 дүгээр сар 24

Дугаар .2...

Улиастай сум

Дүрэмд өөрчлөлт оруулж компаниййн хэлбэрийг өөрчлөх тухай

Компаний бүх гишүүдийн хурлаас тогтоох нь:

1. Компаний хувьцааны төвлөрөл, орон нутгийн онцлог, Монголын санхүү хөрөнгийн зах зээлийн өнөөгийн хөгжлийн байдал зэргийг үндэслэн Завханбаялаг Хувьцаат компанийг Хаалттай хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсугай.
2. Компаний дүрмийн .. -р зүйлд хаалттай хувьцаат компани гэж нэмэлт өөрчлөлт оруулсугай.
3. Компаний дүрмийн .. -р зүйлд Аудитын байгууллагыг заавал ажиллуулах гэж нэмэлт өөрчлөлт оруулсугай.
4. Компаний дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлийн газарт бүртгүүлж баталгаажуулахыг ТУЗ-д даалгасугай.
5. Компаний тухай болон бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан шийдвэр зөвлөмжийн дагуу Компаний өөрчлөлтийн материалыг бүрдүүлж, өөрчлөлтийг хувьцаа эзэмшигч нарт мэдэгдэж эрх ашгийг хамгаалж дүнг хуралд танилцуулахыг ТУЗ-д үүрэг болгосугай

Хурлын дарга

Ю.Бат-Эрдэнэ

Нарийн бичгийн дарга

Л.Лхамжав

ЗАВХАНБАЯЛАГ ХК-НИЙ БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо 2016 оны 4 дүгээр сар 24

Дугаар .1....

Улиастай сум


Компаний ТҮЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ


Компаний ТҮЗ-ийн гишүүнүүг сонгох тухай нууцаар санал хураалт явуулсан дүн, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Компаний бүх гишүүдийн хурлаас тогтоох нь:

Нэг. Компаний ТҮЗ-ийн гишүүнийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж дор дурьдсан хүмүүсийт ажиллуулхаар баталсугай. Үүнд:

- 1.1. Я.Өлзийбүрэн
- 1.2. Л.Юра
- 1.3. П.Баянмөнх
- 1.4. Ю.Бат-Эрдэнэ
- 1.5. М.Алтанцэцэг
- 1.6. Д. Санжмятав
- 1.7. Ц. Чанцаа
- 1.8. Г. Түвшинбат
- 1.9. Т. Мөнхбаатар

Хоёр. Компаний үр ашгийг дээшлүүлж, үйл ажиллагааг идэвхижүүлэх, менежментийг сайжруулах, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянаж туслах чиглэлээр идэвх гарган ажиллахыг ТҮЗ-д даалгасугай.




Ю.Бат-Эрдэнэ


Л.Лхамжав

“ЗАВХАНБАЯЛАГ” ХК-НИЙ БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2016 оны 4 дүгээр сар 24

Дугаар...5....

Улиастай сум


ЗАРДАЛ БАТЛАХ ТУХАЙ

Компаний бүх гишүүдийн хурлаас тогтоох нь:

1. Завханбаялаг ХК-ний удирдлагын 2016 оны зардлыг 35000000 төгрөгөөр тогтоож 2015 оны зардлын гүйцэтгэлийг 31000000 төгрөгөөр баталсугай.
2. Төсвийг зориулалтын дагуу зарцуулж түүнд тавих хяналтаа сайжруулж ажиллахыг ТУЗ-д хариуцуулсугай.

Хурлын дарга

Нарийн бичгийн дарга



Ю.Бат-Эрдэнэ

Л.Лхамжав

**"ЗАВХАН БАЯЛАГ" ХК-НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ.**

2016.04.24

УЛИАСТАЙ СУМ

Тооллогын дүнгийн тухай тогтоох нь

Компаний 2015 онд хийсэн ажлын тайлан, цаашдын зорилтийг батлах, компаний 2015 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын дүгнэлтийг батлах, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, Компанийн удирдлагын зардлыг батлах, Ашиг хувиарлах эсэх тухай тогтоол, Аудитын байгууллагыг сонгох гэрээг батлах, ТУЗ-н гишүүдийг сонгох, ТУЗ-ын төсөвийг батлах асуудлаар явуулсан нууц санал хураалтын дүнг гаргав. Санал хураалтанд нийт 42279 хувцаатай 4 хүн оролцов. Саналын хайрцагийг задлахад 4 хуудас гарч хүчинтэй 4 хуудас байв. Санал хураалтын дүнг танилцуулахад:

1. Компаний 2015 онд хийсэн ажлын тайлан, цаашдын зорилтийг батлах, компаний 2015 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын дүгнэлтийг батлах,-42279 санл өгсөн, татгалзсан санал байхгүй.
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах,-42279 санл өгсөн, татгалзсан санал байхгүй.
3. Компанийн удирдлагын зардлыг батлах,-42279 санл өгсөн, татгалзсан санал байхгүй.
4. Ашиг хувиарлах эсэх тухай тогтоолыг батлах,-42279 санл өгсөн, татгалзсан санал байхгүй.
5. Аудитын байгууллагыг сонгох гэрээг батлах,-42279 санл өгсөн, татгалзсан санал байхгүй.
6. ТУЗ-н гишүүдийг сонгох, ТУЗ-ын гишүүнд 9 хүний нэрийг дэвшүүлсэн ба гишүүн тус бүр дээр санал авсан байдлыг танилцуулвал.

- Я.Өлзийбүрэн –Санал өгсөн 42729, татгалзсан санал байхгүй.
- Л.Юра –Санал өгсөн 42729, татгалзсан санал байхгүй.
- П.Баянмөнх –Санал өгсөн 42729, татгалзсан санал байхгүй.
- Ю.Бат-Эрдэнэ –Санал өгсөн 42729, татгалзсан санал байхгүй.
- М.Алтанцэцэг –Санал өгсөн 42729, татгалзсан санал байхгүй.
- Д.Санжмятав–Санал өгсөн 42729, татгалзсан санал байхгүй.
- Ц.Чанцаа –Санал өгсөн 42729, татгалзсан санал байхгүй.
- Г.Түвшинбат –Санал өгсөн 42729, татгалзсан санал байхгүй.
- Т.Мөнхбаатар –Санал өгсөн 42729, татгалзсан санал байхгүй.

1. Компаний 2015 онд хийсэн ажлын тайлан, цаашдын зорилт, компаний 2015 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын дүгнэлт, Ашиг хувиарлах эсэх тухай тогтоолыг батлах тухай ... тоот тогтоол
2. Компанийн удирдлагын зардлыг батлах тухай... тоот тогтоол
3. ТУЗ-н гишүүдийг сонгох тухай ... тоот тогтоол
4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай ... тоот тогтоол

Тооллого явуулсан комиссын дарга.....Л.Лхамжав



ГишүүнД.Даваажаргал